ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түдэвтэй сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/123/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр
орлон гүйцэтгэгч : Г.Заяа
Утас:92038288
Цахим хаяг:zayag@audit.gov.mn

Интер аудит ХХК
Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг
Утас: 99469299, 90111091
Цахим хаяг: altan_fin@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.Аудитын санал дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....13
3. Аудитын тайлан....14
3.1 Ерөнхий зүйл ....14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....14
3.4 Материаллаг байдал ....15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....16
3.8 Аудитын гол асуудал ....16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.... 17
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.... 17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....17
4. Аудитын илрүүлэлт ....17
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит....17
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит ....17
4.2.1 Залруулсан алдаа.... 17
4.2.2 Төлбөрийн акт.... 17
4.2.3 Албан шаардлага .... 18
4.2.4 Зөвлөмж .... 18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| НҮБ | Нэгдсэн үндэсний байгууллага |
| ТАХ | Төрийн албан хаагч |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөх бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |

## 1.Аудитын санал дүгнэлт

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.21 № 1302/91

танай ______ -ны № ______ -т

ТҮДЭВТЭЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түдэвтэй сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Түдэвтэй сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

*37.9 сая төгрөгийн түлш халаалтын материал, 48.2 сая төгрөгийн эм бэлдмэлийг нийлүүлэх гүйцэтгэгчийг хууль журмын дагуу сонгон шалгаруулаагүй, эм бэлдмэлийг сумын эргэлтийн эмийн сангийн худалдан борлуулж буй үнээс өндөр үнээр худалдан авч төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь* (Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1, Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.4 дэх заалтуудтай) нийцэхгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

013022001

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, *дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.*

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **22,714.70** | **59,347.37** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 638.72 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | 1.60 |
| 31130 | Нэмэлт санхүүжилт | - | 1.60 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 637.12 |
| **3121** | **Төгрөг** | - | 637.12 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 637.12 |
| **33** | **АВЛАГА** | - | 15,929.11 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 539.91 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 15,110.50 |
| **335** | **Бусад авлага** | - | 278.70 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 278.70 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 22,714.70 | 42,779.54 |
| **351** | **Түүхий эд материал** | 4,000.00 | 6,842.61 |
| 35130 | Эм боох материал | 4,000.00 | 6,842.61 |
| **354** | **Хангамжийн материал** | 18,714.70 | 35,936.93 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 159.40 | 1,667.40 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,000.79 | 17,194.24 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 1,807.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,915.95 | 1,620.30 |
| 35460 | Хүнсний материал | 2,935.76 | 3,739.19 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,702.80 | 9,908.80 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **860,839.53** | **843,842.44** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 860,839.53 | 843,842.44 |
| **392** | **Биет хөрөнгө** | 834,855.53 | 817,858.44 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 699,102.61 | 699,102.61 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (25,667.90) | (41,650.97) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 56,131.43 | 56,131.43 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (31,248.33) | (37,156.43) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 394,403.69 | 447,848.36 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (262,761.40) | (313,037.01) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 25,713.43 | 28,497.23 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (20,857.59) | (21,916.38) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 30.30 | 30.30 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (30.30) | (30.30) |
| 39217 | Ном | 39.60 | 39.60 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 25,984.00 | 25,984.00 |
| 39301 | Програм хангамж | 490.00 | 490.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (490.00) | (490.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,984.00 | 25,984.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **883,554.24** | **903,189.80** |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **278.70** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 278.70 |
| **413** | **Өглөг** | - | 278.70 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 278.70 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 278.70 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **883,554.24** | **902,911.10** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 883,554.24 | 902,911.10 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 617,572.18 | 617,572.18 |
| 51101 | Өмч: - төрийн | 617,572.18 | 617,572.18 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 117,156.47 | 136,513.34 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (56,758.94) | 117,156.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 173,915.41 | 19,356.87 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 148,825.59 | 148,825.59 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **883,554.24** | **903,189.80** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **835,186.44** | **686,813.63** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **269,139.79** | **114,813.81** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 269,139.79 | 114,813.81 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 269,139.79 | 114,813.81 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,832.58 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,378.45 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 258,928.76 | 114,813.81 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **566,046.66** | **753,999.82** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 514,073.10 | 563,037.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 514,073.10 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 563,037.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 132,944.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 116,809.50 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 1,024.50 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | - | 15,110.50 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 44,150.90 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 44,150.90 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 51,973.56 | 13,867.42 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 51,973.56 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 13,867.42 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **650,283.78** | **849,456.76** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **650,283.78** | **849,456.76** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 647,607.51 | 794,194.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 379,531.40 | 436,262.34 |
| 210101 | Үндсэн цалин | 379,531.40 | 234,756.83 |
| 210102 | Нэмэгдэл | - | 156,362.72 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 6,670.00 |
| 210104 | Урамшуулал | - | 38,472.79 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 48,272.08 | 56,050.71 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,283.28 | 38,906.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,747.20 | 4,364.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,997.80 | 3,559.64 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 749.40 | 773.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,494.40 | 8,446.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,652.57 | 39,842.79 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,453.99 | 3,504.30 |
| 210302 | Түлш, халаалт | 33,789.01 | 36,288.49 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 409.57 | 50.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,715.88 | 31,297.76 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,797.60 | 2,924.50 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,039.48 | 23,262.36 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 299.30 | 429.10 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 60.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,650.00 | 2,410.80 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000.00 | 1,293.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,929.50 | 918.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 67,313.27 | 132,420.13 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 51,249.30 | 120,088.59 |
| 210502 | Хоол, хүнс | 15,541.48 | 12,331.54 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 522.50 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,698.60 | 7,159.10 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 505.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 2,193.60 | 7,159.10 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,693.00 | 2,384.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,693.00 | 2,384.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,207.79 | 2,766.29 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 686.90 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 144.00 | 400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 504.90 | 500.93 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 64.00 | 64.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 96.09 | 44.41 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,008.90 | 1,096.57 |
| 210807 | Газрын төлбөр | 26.90 | 25.99 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 44.10 | 2.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 632.00 | 632.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 85,522.92 | 86,010.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,545.05 | 12,785.38 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 73,977.87 | 73,225.56 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,676.26 | 55,262.71 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 580.00 | 55,191.50 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 41,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 580.00 | 13,591.50 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,096.26 | 71.21 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,096.26 | 71.21 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **184,902.67** | **19,356.87** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 10,987.26 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 10,987.26 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (10,987.26) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **173,915.41** | **19,356.87** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 617,572.18 | 148,825.59 | (56,758.94) | 709,638.82 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **617,572.18** | **148,825.59** | **(56,758.94)** | **709,638.82** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 173,915.41 | 173,915.41 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **617,572.18** | **148,825.59** | **117,156.47** | **883,554.24** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **617,572.18** | **148,825.59** | **117,156.47** | **883,554.24** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **617,572.18** | **148,825.59** | **117,156.47** | **883,554.24** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 19,356.87 | 19,356.87 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **617,572.18** | **148,825.59** | **136,513.34** | **902,911.10** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **576,257.69** | **738,889.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,211.03** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,211.03 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 10,211.03 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,832.58 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,378.45 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **566,046.66** | **738,889.32** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 514,073.10 | 563,037.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 514,073.10 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 563,037.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 117,834.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 116,809.50 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 1,024.50 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 44,150.90 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 44,150.90 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 51,973.56 | 13,867.42 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 51,973.56 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 13,867.42 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **576,257.69** | **735,267.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **576,257.69** | **735,267.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **573,581.42** | **680,004.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 379,531.40 | 436,262.34 |
| 210101 | Үндсэн цалин | 247,787.54 | 234,756.83 |
| 210102 | Нэмэгдэл | 87,451.17 | 156,362.72 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,719.30 | 6,670.00 |
| 210104 | Урамшуулал | 37,573.40 | 38,472.79 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 48,254.59 | 56,590.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,265.79 | 39,446.02 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,747.20 | 4,364.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,997.80 | 3,559.64 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 749.40 | 773.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,494.40 | 8,446.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38,352.57 | 39,542.79 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,453.99 | 3,504.30 |
| 210302 | Түлш, халаалт | 34,489.01 | 35,988.49 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 409.57 | 50.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,922.83 | 31,892.11 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,718.10 | 4,432.50 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,255.43 | 23,266.71 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 299.30 | 429.10 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 60.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,650.00 | 2,410.80 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000.00 | 1,293.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 68,009.42 | 81,633.75 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 50,191.10 | 64,389.78 |
| 210502 | Хоол, хүнс | 15,961.32 | 13,537.97 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,857.00 | 3,706.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,583.58 | 12,755.10 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,389.98 | 3,979.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 500.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,193.60 | 8,276.10 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,693.00 | 2,384.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,693.00 | 2,384.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,207.79 | 2,766.29 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 686.90 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 144.00 | 400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 504.90 | 500.93 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 64.00 | 64.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 96.09 | 44.41 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,008.90 | 1,096.57 |
| 210807 | Газрын төлбөр | 26.90 | 25.99 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 44.10 | 2.40 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 632.00 | 632.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,026.25 | 16,177.90 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,026.25 | 16,177.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,676.26** | **55,262.71** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 580.00 | 55,191.50 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 41,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 580.00 | 13,591.50 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,096.26 | 71.21 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,096.26 | 71.21 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **3,621.72** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **2,983.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **2,983.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 2,983.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 2,983.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(2,983.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 638.72 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 638.72 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 657,043.40 | 620,346.99 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 657,043.40 | 620,346.99 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 656,143.40 | 619,446.99 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 436,262.40 | 436,262.34 |
| 210101 | Үндсэн цалин | 257,871.30 | 234,756.83 |
| 210102 | Нэмэгдэл | 127,965.00 | 156,362.72 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,768.20 | 6,670.00 |
| 210104 | Урамшуулал | 42,657.90 | 38,472.79 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 58,312.60 | 56,590.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,882.60 | 39,446.02 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,357.50 | 4,364.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,486.00 | 3,559.64 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 871.50 | 773.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,715.00 | 8,446.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,413.30 | 39,542.79 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,994.80 | 3,504.30 |
| 210302 | Түлш, халаалт | 37,984.30 | 35,988.49 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 434.20 | 50.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,617.50 | 21,255.09 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,214.40 | 3,214.40 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,793.80 | 15,261.79 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 299.30 | 299.30 |
| 210404 | Ном, хэвлэл | 60.00 | 60.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,250.00 | 1,235.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,000.00 | 1,184.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 66,085.40 | 42,767.82 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 48,179.10 | 34,983.95 |
| 210502 | Хоол, хүнс | 13,940.30 | 4,938.87 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,966.00 | 2,845.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,227.60 | 9,918.90 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,900.00 | 4,882.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 790.00 | 500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,537.60 | 4,536.90 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,500.00 | 1,642.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,500.00 | 1,642.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,879.80 | 2,766.29 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл | 400.00 | 400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | тогтоох | | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 504.90 | 500.93 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 64.00 | 64.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99.00 | 44.41 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,108.90 | 1,096.57 |
| 210807 | Газрын төлбөр | 26.90 | 25.99 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 44.10 | 2.40 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 632.00 | 632.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,844.80 | 8,701.15 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,844.80 | 8,701.15 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 900.00 | 900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 900.00 | 900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 900.00 | 900.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 657,043.40 | 620,984.11 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 46,950.90 | 44,079.69 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 46,950.90 | 44,079.69 |
| 122004 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 50,855.50 | 13,867.42 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 559,237.00 | 563,037.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 0.001 | 0.001 |
| 610001 | Төсвийн байгууллага | 0.001 | 0.001 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 0.030 | 0.031 |
| 620001 | Удирдах ажилтан | 0.001 | 0.001 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 0.026 | 0.027 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 0.003 | 0.003 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **117,832.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **117,832.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 63,540.90 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,637.02 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,218.10 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,004.92 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 129.80 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,175.20 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 109.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,865.93 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 29,405.83 |
| 210502 | Хоол, хүнс | 8,599.10 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 861.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,819.20 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,080.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,739.20 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 742.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 742.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,476.75 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,476.75 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 54,291.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 54,291.50 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 41,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,691.50 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 117,834.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 117,834.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 116,809.50 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,024.50 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **1.60** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1.60 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Түдэвтэй сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Түдэвтэй сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн №02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түдэвтэй сумын эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.4, эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түдэвтэй сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн 657.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 6.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 70 хувь буюу 4.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 638.72 | 638.72 |
| Авлага | - | 15,929.11 | 15,929.11 |
| Бараа материал | 22,714.70 | 42,779.54 | 20,064.84 |
| Үндсэн хөрөнгө | 860,839.53 | 843,842.44 | (16,997.10) |
| **Нийт хөрөнгө** | **883,554.24** | **903,189.80** | **19,635.57** |
| Өр төлбөр | - | 278.70 | 278.70 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 883,554.24 | 902,911.10 | 19,356.87 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **883,554.24** | **903,189.80** | **19,635.57** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0.6 сая төгрөгөр өссөн нь коронагийн бэлэн байдлыг хангахтай холбоотой мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зөвшөөрсөнтэй холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 15.9 сая төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбоотой авлага 0.5 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 15.1 сая, бусад авлага 0.3 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 20.1 сая төгрөгөөр өссөн нь 141.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандив, үнэ төлбөргүй орлогоор 61.6 сая төгрөгийн эм боох болон хүнсний материал бэлтгэн, 182.9 сая төгрөгийн бараа материал үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17.0 сая төгрөгөөр буурсан нь 3.0 сая төгрөгийн эмнэлэгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, үнэ төлбөргүй орлогоор 53.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэн, 73.2 сая төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.28 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 19.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 50.9 сая, орон нутгийн төсвөөс 46.9 сая, улсын төсвөөс 559.2 сая, нийт 657.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 657.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 563.0 сая, орон нутгийн төсвөөс 44.0 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 13.9 сая, нийт 620.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 620.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 116.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 1.0 сая төгрөг, нийт 117.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 63.5 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 54.3 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 12.9 сая төгрөгийн авлагаас эмнэлгийн зориулалттай үндсэн хөрөнгө бэлтгэх шийдвэр бүхий 8.6 сая төгрөгийн санхүүжилтийг хасаж, 4.3 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд нь буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

### 3.8 Аудитын гол асуудал

Шилэн дансны мэдээллийг хууль, журмын дагуу үнэн зөв мэдээлээгүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 онд нийт 948.6 сая төгрөгийн 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 209.9 сая төгрөгийн 18 мэдээллийг ил тод байршуулаагүй, 226.8 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрсэн.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд шилэн дансны 8 мэдээлэл хугацаа хоцорсон, 38 мэдээлэл байршуулаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

## 4. Аудитын илрүүлэлт

### 4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Завсарын үеийн аудитад хамрагдаагүй байна.

### 4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 89.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 36.3 сая төгрөгийн алдааг залруулж, 4.9 сая төгрөгийн алдаанд төлбөрийн акт, 48.2 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

#### 4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 36.3 сая төгрөгийн залруулга хийгдсэн. Үүнд:

*1.1.* *<u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *Хандиваар өгсөн 1.5 сая төгрөгийн зүрхний тоног төхөөрөмж орлогод аваагүй.*
- ✓ *34.8 сая төгрөгийн халаалтын зардлыг бараа материалын дансаар дамжуулан бүртгэсэнтэй холбоотой санхүү тайлангийн тодруулга алдаатай илэрхийлэгдсэн.*

*1.2.* *<u>Шийдвэрлэлт:</u>*

- ✓ *УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толиуулга, УСНББОУС-15 Санхүүгийн хэрэглүүр: тодруулга ба толилуулга зэрэг стандартуудтай нийцээгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй тул тайланг засварлуулсан.*

#### 4.2.2 Төлбөрийн акт

*1.1.* *<u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *Ажилтнуудад 0.3 сая төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү тооцож олгосон.*
- ✓ *Сахилгын шийтгэлтэй 2 ажилтанд 0.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.*
- ✓ *Ковидоор өвчилсөн иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын хэмнэлт буюу тухайн төсвийн жилд ашиглагдаагүй төсвийн үлдэгдэл болох 12.9 сая төгрөгийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулах нөхцөл байдал үүссэн.*

*1.2. <u>Шийдвэрлэлт:</u>*

- ✓ *12.9 сая төгрөгийн авлагын дүнгээс сумын ИТХ-ын 10 дугаар тогтоолын дагуу эмнэлэгийн зориулалттай үндсэн хөрөнгө бэлтгэх 8.6 сая төгрөгийг хасаж үлдэх 4.3 сая төгрөгийн зөрчилд, илүү олгосон урамшуулал, нэмэгдэл цалин зэрэгт төлбөрийн акт тогтоолоо.*

### 4.2.3 Албан шаардлага

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *37.9 сая төгрөгийн түлш халаалтын материал, 48.2 сая төгрөгийн эм бэлдмэлийг нийлүүлэх гүйцэтгэгчийг хууль журмын дагуу сонгон шалгаруулаагүй, эм бэлдмэлийг сумын эргэлтийн эмийн сангийн худалдан борлуулж буй үнээс өндөр үнээр худалдан авч төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, эмийн худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулаагүй байна.*

*1.2. <u>Шийдвэрлэлт:</u>*

- ✓ *Босго үнээс давсан төсөвт өртөг бүхий бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу хийж, төсвийг хэмнэлттэй зарцуулж байх үүргийг албан шаардлага хүргүүлж байна.*

### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

*1.3. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *2021 онд нийт 948.6 сая төгрөгийн 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 209.9 сая төгрөгийн 18 мэдээллийг байршуулаагүй, 226.8 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.*

*1.4. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

- ✓ *Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж оноо 88 байгаа тул зөвлөмж хүргүүллээ.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн аудитын асуудал** | | | | | | | | | | | |
| | Түдэвтэй сумын эрүүл мэндийн төв | 7 | 89.4 | 2 | 36.3 | 3 | 4.9 | 1 | 48.2 | 1 | |
| **Дүн** | | **7** | **89.4** | **2** | **36.3** | **3** | **4.9** | **1** | **48.2** | **1** | |